

# Шинэ жилийн гэрлэн хэлхээ

Шинэ жил болох гэж байхад хотод цас ороогүй байгаад Поликарп гутарч байна. Тэр шинэ жилийн уур амьсгал оруулахын тулд гэрээ гэрлэн хэлхээгээр чимэглэхээр шийдэв.

Дэлгүүр энэ жил “Өөрийн чимэглэлийг өөрөө бүтээе” нэртэй үйлчилгээ үзүүлж байгаа. Та улаан, ногоон, цэнхэр өнгийн гэрлүүдээс сонгон авч дэлгүүрийн ажилчдаар гагнуулан шулуун хэлхээ үүсгэж өгнө. Эцэст нь үүссэн хэлхээнд ижил өнгийн 2 гэрэл зэрэгцэн орохгүй юм.

Жишээ нь та 3 улаан, 3 ногоон, 3 цэнхэр өнгийн гэрэл сонгосон бол ажилчдын үүсгэсэн хэлхээ ийм байж болно : “RGBRBGBGR” (“RGB” нь харгалзан улаан, ногоон, цэнхэр өнгийн гэрлүүд гэсэн үг). Хэлхээний хоёр захын гэрэл адил өнгөтэй байж болно.

Гэвч та 1 улаан, 10 ногоон, 2 цэнхэр өнгийн гэрэл сонгосон бол ажилчид танд нөхцөлийг хангах хэлхээ үүсгэж өгч чадахгүй. Учир нь эдгээр гэрлүүдээр үүсгэсэн ямар ч хэлхээнд заавал ижил өнгийн гэрэл дараалж орно.

Тэгэхээр Поликарп хэдэн гэрэл худалдаж авсан ба түүгээр гэрлэн хэлхээ хийж болох эсэхийг мэдэхийг хүсэж байна. Хэрэв болох бол “Yes” үгүй бол “No” гэж хэвлэх алгоритм бичнэ үү.

## Input

Эхний мөрөнд ганц бүхэл тоо  $t$  ( $1 \leq t \leq 100$ ) байна. Поликарпийн сонголтуудын тоо.

Дараагийн мөр болгонд  $r, g$  ба  $b$  ( $1 \leq r, g, b \leq 10^9$ ) гэсэн гурван тоо өгөгдөнө. харгалзан улаан, ногоон, цэнхэр өнгүүдийн тоо.

## Output

$t$  мөр хэвлэнэ. Уг гэрлүүдээр хэлхээ үүсгэж болох бол “Yes” үгүй бол “No” гэж хэвлэнэ.

## Example

### Input:

3

3 3 3

1 10 2

2 1 1

### Output:

Yes

No

Yes